



СОЙМБОМ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№104 /318/

2022.06.02

Цаг үе, үйл явдал

БХЯ, ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССТОЙ ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГТ ГАРЫН ҮСЭГ ЗУРАВ



Монгол Улсын Батлан хамгаалах яам, Хүний эрхийн Үндэсний комисстой 2022-2024 он хүртэл хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, баталгаажуулав. Энэхүү санамж бичгийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ХЭУК-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, гишүүн Ж.Хунан нар үзэглэв.

Санамж бичигт Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын болон хүмүүнлэгийн эрх зүйн гэрээ, конвенц, бусад хууль тогтоомжийг удирдлага болгон цэргийн алба хаагчдын хуульд заасан эрхийг баталгаатай хангуулах, цэргийн нэгтгэл, анги, байгууллага дахь дүрмийн бус харьцаа, хүний эрхийн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цэргийн алба хаагчдад хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх, Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг хэрэгжүүлж, хоёр байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг олон зорилтыг тусгажээ.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр энэ үеэр хэлсэн үгэндээ “Бидний хамтын үйл ажиллагааны үр дүнд хүний эрх нь элдэв баримт бичигт чимэг болгож хэрэглэгддэг тунхгийн шинжтэй үг биш, харин цэргийн алба хаагчид хоорондоо хэрхэн зөв дүрмийн дагуу харьцах харьцааг тодорхойлж, харьцаа хандлагыг өөрчилж, хүний эрх бол нийгмийн үнэт зүйл гэдгийг ойлгуулахад чухал ач холбогдолтой” гэдгийг цохон тэмдэглэсэн юм.

Ташрамд, Хүний эрхийн Үндэсний комиссоос 2006, 2016, 2021 онуудад Зэвсэгт хүчний ажилтан алба хаагчдын хөдөлмөрлөх эрх, ажиллах орчин, нөхцөл, дүрмийн бус харьцааны талаар судалгаа, дүгнэлт, хяналт шалгалтын ажлыг хийж, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр ирүүлсэн шаардлага, зөвлөмжийн дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа юм.

АНГИЙН ЗАХИРАГЧ ДУУЛЖ ХҮҮХЭД БАГАЧУУЛДАА МЭНДЧИЛГЭЭ ДЭВШҮҮЛЭВ



аймгийн хүүхдийн паркт хүрэлцэн ирсэн юм. Тус өдөрлөгт нийтдээ 80 гаруй хүүхдүүд оролцсон бөгөөд тэдний дунд /0-3, 4-9, 10-18/ насны ангиллаар хуваан “Азын бөмбөг”, “Би бүжигчин”, “Гар зургийн уралдаан”-ыг зохион байгуулсан юм. Тус өдөрлөгийн гол зорилго нь хүүхдүүдэд үнэтэй бэлэг өгөх бус тэдний хүүхэд ахуй насыг аз жаргал, инээд хөөр, баяр баясалтай байлгах, үеийн олон нөхөдтэйгөө, хайртай эцэг эхтэйгээ юугаар ч орлуулшгүй дурсамжийг бүтээх нь байлаа.

Өдөрлөгийн хүрээнд “Сэтгэл зүйгээ ойлгоё”, “Хамгийн сайхан зүйлс үнэгүй”, “Үнэ цэн”, “Миний мэргэжил-Миний бахархал” гэсэн 4 буфет ажиллуулсан нь алба хаагчдын болон хүүхдүүдийн сонирхлыг ихэд татсан юм. “Хайраар цэнэглэе” өдөрлөгийн төгсгөлд “Squid game” киноны аянд хүүхдүүдийг тоглуулсан нь тэднийг улам хөгжөөсөн билээ. Мөн ангийн удирдлагын зүгээс өдөрлөгт оролцсон бүх хүүхдүүдийг хүүхдийн паркт 50 %-ийн хөнгөлөлттэй үнээр тоглууллаа.

Зэвсэгт хүчний 340 дүгээр анги

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан “Хайраар цэнэглэе” арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд ангийн захирагч хурандаа У.Буянжаргал “Хэрвээ сайхан амьдарч байвал” дуугаар ая дууны мэндчилгээ дэвшүүлсэн нь ангийн бие бүрэлдэхүүн болон тэдгээрийн гэр бүлд гэнэтийн сюрприз байлаа. Ангийн захирагч хурандаа У.Буянжаргал нь автын инженер мэргэжилтэй хэдий ч “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-т зориулан нэлээдгүй хэд хоног мэндчилгээ дэвшүүлэх дууныхаа бэлтгэлээ хийсэн тухайгаа уулзалтын

үеэр ярьж байсан юм. Тэрээр баярын үйл ажиллагааг нээж эцэг эхчүүд, хүүхдүүдэд хандаж хэлсэн үгэндээ “Хүүхэд нас гэдэг бол хамгийн гэгээхэн, цагахан, нандин үе байдаг. Тиймдээ ч ангийн удирдлагын зүгээс та бүгдийн амьдрах таатай орчин нөхцөл, алба хаагчид нэг бүр хүүхдүүддээ тусгайчлан цаг гаргах нөхцөл байдлыг нэмэгдүүлэх, цаашлаад сурах их үйлсэд тань зогсолтгүйгээр тусалж, дэмжих тухайгаа” илэрхийллээ. “Хайраар цэнэглэе” өдөрлөгийн хүрээнд ангийн автобусыг хүүхдүүдийн үзэх дуртай “Тау” хүүхэлдэйн киноны баатраар чимэглэж, ангийн байрлалаас хүндэт бяцхан зорчигчдоо суулган Баян-Өлгий



“СУР ХАРВАА”-ГААР БАХДАМ АМЖИЛТ ҮЗҮҮЛЛЭЭ

Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн холбооны албаны техник хэрэгслийн инженер Б.Мөнхцэцэг тус ангид томилогдоод удаагүй байгаа ч анги байгууллагаа төлөөлөн Баян-Өлгий аймгийн аварга шалгаруулах “Халх сур”-ын тэмцээнд оролцон Тэргүүн байр эзэлж ангийнхаа нэрийг өндөрт өргөсөн бахдам амжилт гаргалаа.

Тэрээр Үндэсний Батлан Хамгаалахын Их сургуулийг холбооны инженер мэргэжлээр 2021 онд

суралцаж төгссөн бөгөөд сур харваагаар 7 дахь жилдээ хичээллэж байна. Түүний амжилтуудаас дурдвал:

2019 онд Баян-хонгор аймгийн Улсын баяр наадмын тэмцээнд аймгийн “Гарамгай харваач”;

2019 онд “Спортын дэд мастер”;

2020 онд Монголын Үндэсний харваачдын холбооны түүхт 80 жилийн ойн улсын аварга шалгаруулах тэмцээнд нийт 40

сумнаас 36-г онож спортын мастер цол авч, нийлбэр дүнгээр 5 дугаар байрт тус тус шалгарч байжээ.

Түүний өвөө нь бэлтгэл дэд хурандаа Жамц овогтой Дэлгэр нь мөн холбооны инженер мэргэжилтэй байсан ба Хил хамгаалах газраас гавьяаны амралтаа авсан. Удам залгасан цэргийн холбоочин охины цаашдын ажил, амьдралд амжилт бүхний дээдийг хүсэн ерөөе.

Ахлах дэслэгч Б.ДОЛГОРСҮРЭН



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
17	3

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	27

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,124.00	3,126.0
EUR	3,340.0	3,365.0
CNY	466.00	468.50
RUB	47.00	47.50
JPY	24.00	24.50
KRW	2.52	2.54

ЗУРХАЙ



2022.06.03 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 4

ЗУНЫ ИЛҮҮ ТЭРГҮҮН САРЫН ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ УЛААГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулбал:
Бие эрхтний хүч сайжирна
Наран ургах, шингэх:
04.56-20.44
Барилдлага:
Үл тохирох
Шүтэн барилдлага:
Хурьцахуй
Суудал: Хий

Энэ өдөр хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, бие эхнрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, хараал, жатхыг буцаах, нялхсын хурим хийх, огторгуйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Газар ухах, худаг гаргах, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу.

Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод урд зүгт мөрөө гаргавал зохистой. Модон хохимой өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал бие эрхтний, хүч сайжирна.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 534,142,942

Эдгэрсэн

Нийт: 505,074,570

Нас барсан

Нийт: 6,317,460

Цахим шууданд

ХҮҮХЭД ШУУГЬСАН НЭГЭН ӨДӨР БАЙЛАА



үзэсгэлэн үзсэн баяр хөөрөөр дүүрэн нэгэн өдөр байлаа. Алба хаагчдын 175 хүүхэд багачууд хүрэлцэн ирсэн бөгөөд хүүхдүүдийн дунд 5 төрлийн тэмцээнийг насны ангиллаар зохион байгуулан шилдгүүдийг өргөмжлөл, гарын бэлгээр урамшууллаа. Энэ үеэр ангийн эмэгтэйчүүд хүүхэд багачуудаар сугалаа сугалуулж азтаныг шалгаруулахыг зэрэгцээ ангийн ахлагч Б.Отгонтамирын гэргий шүдний эмч Б.Жавзмаа хүүхэд багачуудын шүдэнд үзлэг хийж зөвлөгөө өглөө.

Ахмад Б.ДЭРДЭНЭНИНЖ

Зэвсэгт хүчний 350 дугаар анги

Ангийн удирдлага, эмэгтэйчүүдийн зөвлөл хамтран "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг угтан алба хаагчдынхаа гэр бүл, үр хүүхдүүдийг ангийн байрлалд хүлээн авч хүндэтгэл үзүүлээ.

Арга хэмжээг нээж ангийн захирагч хурандаа Ж.Сүх-Очир мэндчилгээ дэвшүүлж, авьяаслаг бяцхан багачууд дуулж, шүлэг уншиж, бүжиглэн, хоорондоо уралдаж, тоглоомоор тоглож, зэвсгийн



"АЗ ЖАРГАЛ БЭЛЭГЛЭГЧИД"



Зэвсэгт хүчний 284 дүгээр анги

Өхөөрдөм үрсийн баясгалантай инээдэд хорвоо дэлхий баясан цэнгэж, үлэмж ачит ээжийн бүүвэйн дуунд буурал дэлхий уяран хайлсан зуны энэ өдөр "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр" тохиож байна.

"Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг угтан Зэвсэгт хүчний 284 дүгээр ангийн удирдлага

болон эмэгтэйчүүдийн зөвлөл хамтран 5 дугаар сарын 31-ний өдөр нийт бие бүрэлдэхүүнийхээ гэр бүлийнхнийг хүлээн авч, хүүхэд, багачуудаа баярлууллаа. Тус арга хэмжээний хүрээнд энтертаймент Пороро ба түүний нөхөд хүрэлцэн ирж, хүүхдүүдийн дунд насны ангиллаар нь "Монгол цэрэг-дэлхийн цэрэг" гар зургийн уралдаан, скүтерийн, ролийн тэмцээнүүдийг тус тус зохион

байгуулж, авьяас билиг, ур чадвараараа манлайлсан хүүхдүүддээ баяр хүргэж, батламж, үнэ бүхий зүйл, бэлэг гардууллаа.

Хүрэлцэн ирсэн зочдодоо авьяаслаг хүүхэд багачууд маань урлагийн тоглолтоор мэндчилгээ дэвшүүлж, хүндэтгэлийн зоог барьж, дурсгалын зураг татуулан нэгэн өдрийг аз жаргалтай, дурсамжтай, инээд хөөрөөр дүүрэн өнгөрөөлөө.

"ҮНЭ ЦЭН" МЮЗИКЛИЙГ ҮЗЭХИЙГ УРЬЖ БАЙНА

Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын 90 жилийн ой, Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойд зориулан бүтээсэн "Үнэ цэн" мюзикл үзэгчдийн хүртээл болсоор байгаа билээ. Энхийг сахиулагч Монгол цэргүүдийн бахархал, эрчүүдийн нөхөрлөл, энхийг дэмжих ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэх хугацаанд тохиолдох олон үйл явдал, тэсвэр тэвчээрийг илтгэн харуулах тус бүтээлийг зорин ирэх үзэгчид сэтгэл дүүрэн агаад гайхам мэдрэмжийг авч байгаагаа илэрхийлсээр байна.

"Монгол цэрэг Дэлхийн цэрэг" хэмээх их алдрыг уран бүтээлээр дамжуулан дархалж, энхийг сахиулагч цэргүүдийнхээ хийморийг бадрааж буй "Үнэ цэн" мюзикл 6 дугаар сарын 3-ны өдрөөс 8-ны өдрүүдэд

Офицеруудын ордонд 18.00 цагаас тоглогдох юм.

Иргэд, цэргийн алба хаагчид, тив, дэлхийд суу алдраа цуурайтуулсан энхийг сахиулагчид Та бүхнийг хүрэлцэн ирж үзэхийг урьж байна.



АЛДАРЫН ӨСВӨР ҮЕ ЗАЛУУЧУУДЫН БАГ ТАМИРЧИД ТЭРГҮҮЛЛЭЭ

"Алдар" спорт хороо

Өсвөр үе залуучуудын U-15, U-20 насны ангиллын чөлөөт бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээн 2022 оны 5 сарын 26-29-ны өдрүүдэд "Аварга" БТДС-ийн спорт зааланд болж өндөрлөлөө.

Уг тэмцээнд Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны МУГД Ц.Хосбаяр, МУГТ Б.Одончимэг, Г.Мандахнаран дасгалжуулагчтай өсвөр үе, залуучуудын баг тамирчид оролцож 2 алт, 4 мөнгө, 10 хүрэл медаль хүртэж, МУГТ Б.Одончимэг дасгалжуулагчтай өсвөр үе залуучуудын эмэгтэй баг тамирчид багаараа тэргүүн байр эзэллээ. Монголын чөлөөт бөхийн залуу бөхчүүдийн залгамж халаа болсон U-15 насны ангиллын тэмцээнээс шалгарсан тамирчид ирэх 7 дугаар сард болох Бахрейны Манама хотод болох Азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхээ аваад байгаа юм.



ЭНХИЙГ САХИУЛАГЧДЫНХАА АР ГЭРТ ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

Зэвсэгт хүчний 338 дугаар анги

Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний түүхт 20 жилийн ойг угтан хурандаа П.Мөнхбат захирагчтай Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн хамт олон энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдынхаа ар гэрийн төлөөллийг хүлээн авч хүндэтгэл үзүүлээ. Энэ үеэр

ангийн танилцуулга, энхийг сахиулах ажиллагааны тухай мэдээллийг хүргэсний зэрэгцээ ангийн үйл ажиллагаатай танилцуулав.

Мөн урлагийн тоглолт, БНӨСУ-аас илгээсэн мэндчилгээг толилуулж, талархлын захидал хадгалуулав. Энэ үеэр ангийн захирагч хурандаа П.Мөнхбат "Хань ижлээ даян дэлхийн энх амгалан, энхийг сахиулах ажиллагаанд үүрэг

гүйцэтгэх хугацаанд ар гэр, үр хүүхдээ харж арыг нь найдвартай бат дааж чадсан та бүгдэд баярлалаа. Та бүгд бол энх цагийн баатрууд юм шүү" хэмээн онцлон хэлэв. Тэгвэл энхийг сахиулагчдын гэр бүлийн гишүүд сэтгэгдэл өндөр байгаагаа илэрхийлэв. Төгсгөлд нь дурсгалын зураг татуулсан юм.

Дэслэгч Б.ПҮРЭВЛХАМ



ХОС АЛТАН МЕДАЛЬТАЙ ДАЙЧИД БАЙГАЛИЙН ДУРСГАЛТ ГАЗРУУДААР АЯЛЛАА

Зэвсэгт хүчний 119 дүгээр анги

Зэвсэгт хүчний болон Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит "Марш-тусгай бэлтгэлийн цогцолбор" тэмцээнээс хос алтан медаль хүртсэн Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн хугацаат цэргийн алба хаагчид энэ сарын 02-ны өдөр "Монгол цэргийн музей", Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлал болон "Цонжин болдог" цогцолбор зэрэг байгалийн дурсгалт газруудаар аяллаа.

Ангид 49 жилийн дараа хос алтан медаль авчирсан дайчдад Төв аймгийн Алтанбулаг сумынхан "Орон нутгийнхаа нэрийг төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдад цуурайтуулж, цэргийн хүний тэсвэр хатуужил, эр зоригороо үлэрлэн хөвө улаа тэргүүлсэнд талархаж байна" хэмээн хүндэтгэл үзүүлсэн бол үүний буухи ангийн аяллын төлөвлөгөөгөөр үргэлжилсэн юм. Химичин дайчид аяллын явцад Зэвсэгт хүчний 13ЦС-А зочилсон бөгөөд энэ үеэр командлалын удирдлагууд хугацаат цэргийн алба нэр төрийг хаах байгаад баяр хүргэж, амжилт хүсч байсан юм.

